



Bayangol Hotel
Since 1964



Хувьцаа эзэмшигчдийн 23-р хуралд зориулав.
2016.04.28



Bayangol Hotel
Since 1964

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ЭРХЭМ ГИШҮҮДЭЭ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит ХХIII хурал 2016 оны 04 сарын 28 өдөр 16 цагт Баянгол ресторанд болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.
ТУЗ-ийн дарга Д.Батжаргал
2. ТУЗ-ийн 2016 оны зардлын төсөв.

Ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын чиглэл болон холбогдох материалыг Та бүхэнд толилуулж байна.

Таныг хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Гишүүд компанийн хурал зарласан байранд 15 цаг 30 минутаас иргэний үнэмлэх, холбогдох бусад бичиг баримттайгаа ирж бүртгүүлж хуралдаа оролцоно уу.

Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал зохион байгуулах комисс
Харилцах утас: 326778, 312255



БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ДЭГ

- | | |
|---|-------|
| 1. Хурлын ирцийг мэдээлэх | 3 мин |
| 2. Хурлын даргыг сонгох | 3 мин |
| 3. Хурал нээх, тооллогын комисс, редакцийн
комиссыг танилцуулах, батлах | 5 мин |
| 4. Компанийн 2015 оны жилийн үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг
хэлэлцэж батлах | |
| 5. ТУЗ-ийн 2015 оны төсвийн гүйцэтгэл, 2016 оны төсөв
батлах | |

ТУЗ-ийн дарга Д.Батжаргал

- | | |
|---|-------|
| 6. Үг хэлэх, санал гаргах /хүн бүр/ | 3 мин |
| 7. Санал хураалт | |
| 8. Санал хураалтын дүн гаргаж хурлаар хэлэлцсэн асуудлын
талаар тооллогын комиссын дүнг сонсох, тогтоол батлах | |

/Цаг тогтоохгүй/

Тайлбар: Хурлыг 2.00 цагт баатанаа.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



Bayangol Hotel
Since 1964

ЭРХЭМ ЗОРИЛГО:

“Баянгол зочид буудал” ХК нь зочидоо дээдэлсэн, зочин бүртээ чин сэргэлээсээ үйлчилдэг байгуулага байна.

АЛСЫН ХАРАА:

“Баянгол зочид буудал” ХК нь зочлохуйн үйлчилгээний салбарт тэргүүлэх чиглэл баримтлан, гадаад до тооодын байгууллагуудтай хамтран ажиллах, олон улсын үйлчилгээний стандарт, дэвшилтэт шинэ үйлчилгээ, техник төхөөрөмж ашиглан, чадварлаг ба г, ажилтантайгаар “Баянгол бренд”-ийн үйлчилгээг буй болгоно.



КОМПАНИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:

- Баянгол зочид буудлын түүхийн анхны хуудас 1964 оны 8-р сарын 12-ны өдрөөс эхэлдэг.
- Сайд нарын Зөвлөлийн 375-р тогтоол гарсан энэ өдрийг Баянгол зочид буудлын түүхийн анхны "шан" татсан өдөр хэмээдэг.
- "Баянгол зочид буудал" нь Засгийн Газрын өмч хувьчлалын Комиссын 1991 оны 12 сарын 11 өдрийн 27-р тогтооолоор "Баянгол зочид буудал"-ыг Хувьцаат Компани болгон, хувийн хэвшлийн аж ахуй болгон өөрчилж, анхны хувь нийлүүлсэн зочид буудал болсон байна. Өнөөдөр 1066 хувь нийлүүлэгчтэй, жил бүр тогтмол ногдол ашиг хуваарилж, үйл ажиллагаа нь тогтмолжсон, хөрөнгийн биржийн ТОП-20 индекст багтдаг томхон хувьцаат компаниудын нэг болсон.
- Хувьцаат компанийн анхны зохион байгуулалтын хурлыг 1991 оны 12-р сарын 26-ны өдөр 180 хувьцаа эзэмшигч гишүүдийн бүрэлдэхүүнтэй хийсэн.
- 1994 оноос 2003 оныг хүртэл "3" одтой зочид буудал
- 2003 оны 6 сард явагдсан Улсын Мэргэжлийн Хяналтын Алба, Дэд Бүтцийн Яам, Аялал Жуучлалын Газраас буудлуудын зэрэглэл тогтоох үзлэгээр "4" одтой зочид буудал болсон.

Баянгол Зочид буудал нь 360 хүн хүлээн авах, таван ангилалын 212 өрөө, 300-450 хүн хүлээн авах боломжтой Баянгол ресторан, Монголын нэг өдөр ресторан, Ази-Европ хоолны ресторан, дээд зэрэглэлийн виноны Wine House кафе-баар, зочны угаалга, өрөөний үйлчилгээ, үсчин гоо сайхан, интернет зэрэг 20 гаруй төрлийн дагалдах үйлчилгээг зочдод үзүүлж байна.



2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ:


Баянгол зочид буудал ХК нь 2015 онд дунджаар үндсэн 160-аад ажиллагадтай зочны урсгалд тохиуулан гэрээт болон улирлын чанартай ажилчид авч ажилуулан, зочин, гийчдээ үйлчлэсэн.

Тайлангийн хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлага үндсэн үйл ажиллагааны чиглэл болох зорилго, зорилтоо тодорхойлж, урьд оны үйл ажиллагааны дүн, тайлант оны зах зээлийн нөхцөл, улирал бүрийн


үйл ажиллагаа, төлөвлөгөөндөө судалгаа, шинжилгээ хийн ТҮЗ-өөр хэлэлцүүлж ажилласан ба дэлхийн болон манай орны санхүү эдийн засгийн хямралын улмаас Монгол улсад ирэх жуулчдын тоо өмнөх жилүүдээс буурсан нь манай үйл ажиллагаанд нөлөөлсөн.

2015 оны улирал, жилийн тайлан тэнцлийг хугацаанд нь гаргаж, аудитийн байгууллагаар баталгаажуулж ажиллалаа.

**Компанийн 2013-2015 оны орлого, зардал, ашгийн харьцуулалт
2013-2015 Income, Expense & Profit**




**2013-2015 оны орлогын задаргаа харьцуулалт
Sub Sector implementation 2013-2015**



2015 онд 386,204 аялагч, жуулчин манай улсад ирсэн бөгөөд 2014 онтой харьцуулахад 2%-иар, 2013 онтой харьцуулахад 8%-иар тус тус буурсан үзүүлэлт гарсан нь зочид буудлын орлого, рестораны өглөө цайны орлогод зохих нөлөөллөө үзүүлсэн.

Улсын хилээр орсон аялагч, жуулчид
Travelers to Mongolia -2015




РЕСТОРАНЫ ОРЛОГЫН ТАЛААР:

Компанийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт 2015 онд өглөөний хоолоор 32'852 хүнд, хүлээн авалтаар 41'622 хүнд, нийт 324'664 порц хоолоор үйлчилсэн байна. Тайлангийн хугацаанд ресторанин орлого 2014 оноос 19%-иар буурсан байна.

Рестораны нийт орлогын 20%-ийг өглөөний хоолны орлого, 61%-ийг нийтийн болон хүлээн авалтын хоол борлуулалтын орлого, 19%-ийг буфетийн бараа борлуулалтын орлого тус тус эзэлж байна.


Рестораны орлогын харьцуулалт
Restaurant income



БУУДЛЫН ОРЛОГЫН ТАЛААР:

Тайлангийн хугацаанд нийт ор хоног ашиглалт 2014 оноос 19%, өрөө ашиглалт 18%-иар буурсан байна. 2015 онд тус зочид буудлаар үйлчлүүлэгчдийн 36.7% нь жуулчин, 46.1% нь гэрээт компаниуд,

0.4% нь элчин сайдын яамд, 16.8% нь бизнес зочид байсан ба буудлын орлого 2014 оноос 16%-иар буурсан үзүүлэлт гарсан байна.




ЗАРДЛЫН ТАЛААР:

2015 онд нийт зардал 4.07 тэрбум төгрөг байгаа нь 2013 оноос 4%-иар нэмэгдсэн, 2014 оноос 8%-иар, төлөвлөсөнөөс 15%-иар буурсан байна. Материалын өртөг, ус, зочны хэрэглээ, БҮТЭЗ зэрэг томоохон зардуулд 18-33%-иар төлөвлөснөөс хэмнэлттэй гарсан нь зочны тоо болон засвар тохижилт, технологийн шинэчлэл хийсэн зэрэгээс хамаарсан. Тайлант жилд орлогын 1 төгрөгт ноогдох зардал 64 мөнгө болж өмнөх оноос 1.5

мөнгөөр өссөн. Энэ нь тогтмол зардлын /цахилгаан, ус, дулаан/ үнийн өсөлт, бараа материалын үнийн өсөлттэй холбоотой байна.

2015 онд инфляцийн өсөлт, 7-р сараас Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос цахилгааны чадлын төлбөр, сэргээгдэх эрчим хүчний төлбөр нэмж авах болсонтой холбоотойгоор цахилгааны зардал 30%-иар мөн ус, дулааны суурь үнэ 5-15%-иар нэмэгдсэн.

Зардал / Expenses




АШИГ, ҮР ДҮНГИЙН ТАЛААР:

2015 онд борлуулалтын орлого төлөвлөлттэй харьцуулбал 22%-иар, өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал 17%-иар, цэвэр ашиг төлөвлөснөөс 19%-иар, 2014 оноос 14%-иар тус тус буурсан байна. Энэ нь манай улсад ирэх жуулчдын тоо өмнөх жилүүдээс буурсан, тогтмол зардал, бараа материалын үнэ өссэн зэргээс шалтгаалж компанийн борлуулалтын орлого


болон цэвэр ашигт нөлөөллөө үзүүлсэн байна, цаашид алба нэгж бүр зардлын бодит судалгаа гарган, дүгнэлт хийх, зардал хэмнэх ажил зохион байгуулна. Маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөө гарган харилцагчийн тоог өмнөх оноос 5%-иар нэмэгдүүлж, цэвэр ашгийг 6%-иар нэмхээр төлөвлөөд байна.

Ашиг / Profit

■ Татварын өмнөх ашиг / Profit before tax ■ Цэвэр ашиг /Net profit/



■ Борлуулалт орлого ■ Цэвэр ашиг



Өнгөрсөн онд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуулийн хугацаанд нь зарлан хуралдуулж нэгж хувьцаанд 355 төгрөгийг ногдол ашиг олгооюр шийдвэрлэсэн бөгөөд тараалт 96%-тай байна.


2015 онд хувьцааны дундаж ханш 46'190 төг болж хаалт ханш 45'000 төгрөг, дээд ханш 54'950 төгрөг болсон нь Монгол улсын үнэт цаасны зах зээлд манай компанийг илэрхийлэх чухал үзүүлэлт юм.

2010-2015 оны судалгаа /Share average

Хөрөнгийн биржийн топ 20 индекс / Market trading TOP 20 index

Year Он	High price Дээд ханш /төг/	Low price Доод ханш /төг/	Closing price Хаалт ханш /төг/	Prev Дундаж ханш /төг/
2010	36450	22000	27500	25590
2011	40000	27000	39500	34821
2012	41900	33000	37500	38511
2013	61000	37000	55000	48176
2014	61000	51000	55000	55284
2015	54950	38020	45000	46190
Year Он	Charter fund Дүрмийн сан /мян.төг/	Staff number Ажиллагсдын дундаж тоо /хүн/	Cost per 1T of sales Орлогын 1 төгрөгт ногдох зардал /мөнгө/	Shareholders Хувьцаа эзэмшигчдийн тоо /хүн/
2010	54905.0	178	52.90	1204
2011	54905.0	175	50.17	1155
2012	54905.0	176	48.70	1137
2013	54905.0	176	52.53	1112
2014	54998.5	176	62.50	1080
2015	54998.5	167	64.00	1066


Нэгж хувьцааны дундаж ханш / The average price per share



Ногдол ашгийн судалгаа
Divident rate

Он	Нэгж хувьцаанд олгосон ноогдол ашиг /төг/	Олгооор тооцсон дүн /мян.төг/	Нэгж хувьцааны зах зээлийн дундаж үнэ	Хувьцааны тоо
2010	343	130728,6	25590	423065
2011	350	133396.6	34821	423065
2012	350	133396.6	38511	423065
2013	355	135169.3	48176	423065
2014	355	135169.3	55284	423065
2015	355	135169.3	46190	423065

Ногдол ашиг / Dividends



2015 оны засвар тохижилт, хөрөнгө оруулалтын талаар:

Тайлант онд томоохон засвар, тохижилтийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд нийт 274.4 сая төг зарцуулсан байна.

- Гадна зам талбайн сайжруулалт бетон хүчилтын ажил
- Холбооны тоног төхөөрөмж шинэчилсэн /ATC/
- Б буудлын гадна үүдэнд ЛЕД дэлгэц шинээр байрлуулсан
- Хөгжмийн шинэ тоног төхөөрөмж
- Рестораны халуун хүйтэн усны магистрал шинэчлэл
- Оффисын үүдны хаалга, дулаалга


2015 ОНЫ ТАТВАР ТӨЛӨЛТИЙН ТАЛААР:

Тайлант хугацаанд улсад төлөх татвар, шимтгэлийг цаг тухайд төлж хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж ирлээ. Үүнд:

Орлогын албан татварт	266'589.1	мян.төг
Нэмүү өртгийн албан татварт	489'775.3	мян.төг
Нийгмийн даатгалын шимтгэлд	337'586.0	мян.төг
Хүн амын орлогын албан татварт	137'245'0	мян.төг
Үл хөдлөх хөрөнгийн татварт	69'929'8	мян.төг
Газрын албан татварт	7'796.0	мян.төг
Машины татварт	1'054.0	мян.төг
ХХАТ	13'698.7	мян.төг

Огноо	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	мян.төг
Улсад төлсөн татвар	1,414,435.3	1,937,989.8	1,575,576.7	1,632,680	1,323,674.0	

Татвар төлөлт
Tax paid



БАЙГУУЛЛАГЫН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛУУД

Ажилчдынхаа нийгмийн асуудалд зориулж 132сая төгрөгийн тусламж, дэмжлэгийг үзүүлсэн, ажилчдын цалинг 10-25%-иар нэмсэн.

Компанийн анхаарлын төвд байдаг чухал асуудлын нэг бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах явдал ба өнөөдөр бид 4 хүнд ажлын байр олгож, дэмжлэг үзүүлж байна.

- Японы зүрх судасны эмгэг согогийн нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн HEART SAVING PROJECT төрийн бус байгууллагын эмч нарын баг, зохион байгуулагч нарыг өөрийн буудалдаа үнэ төлбөргүй байрлуулж “Зүрхний эмгэгтэй хүүхэд бүрийг аварья” гэсэн уриан дор Япон эмч нарын сайхан сэтгэл, үйл ажиллагааг 7 дахь жилдээ дэмжин ажиллаж, зүрхний эмгэгтэй хүүхэд бүрт амьдрал бэлэглэх ариун үйлст 2015 онд 30 гаруй сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
- 2015 оны 3 сард зохион байгуулагдсан Азийн зүүн бүсийн волейболын аврага шалгаруулах тэмцээн ивээн тэтгэгчээр, 2015 оны 7 сард зохион байгуулагдсан жудо бөхийн “Чингис Хаан” Гран При тэмцээний ерөнхий ивээн тэтгэгчээр, 2015 оны 9 сард зохион байгуулагдсан Олон улсын түялзуур сэлэмний ОК СУР тэмцээний ивээн тэтгэгчээр тус тус оролцсон.
- 2015 онд биеийн тамир олон нийтийн арга хэмжээний хүрээнд, хамтран дэмжих ажилладаг “Женко-34” жудо бөхийн клубын тамирчдыг дэмжих ажилласан.
- Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо /МХҮХ/-нд эд материал, бараа бүтээгдхүүнээр тусламж дэмжлэг үзүүлсэн.
- 2015 онд Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд болсон гал түймрийн аюулын үед ажилчдын 1 өдрийн цалинг хандвилсан.
- 2015 онд нарийн мэргэжлийн эмч нараар ажилчидыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байгууллагаас зардлыг даасан.
- Баянгол зочид буудал нь 1991 онд Хувьцаат Компани болсноосоо хойш жил бүр тасралтгүй ногдол ашгаа хувьцаа эзэмшигч нарт хувиарлаж байгаа бөгөөд зөвхөн 2003-2015 онуудад 1 тэрбум 500 сая төгрөгний ногдол ашиг хувиарласан байна.



Bayangol Hotel
Since 1964

БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХК-НИЙ 2016 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Баянгол зочид буудал Хувьцаат компани нь зочдоо дээдэлсэн, зочин бүртээ чин сэтгэлээсээ үйлчилдэг байгуулага.



ЗОРИЛГО-2016:

2016 оны АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын болон зочид гийчдийн тав тухтай, аюулгүй орчныг бүрдүүлж, байгууллагын гадна, дотор засвар тохиижилт, тавилга, тохиромжуудээ шинэчлэх, интернетийн хурдыг нэмэгдүүлэх зэрэг ажилд хөрөнгө оруулалт хийн, мэргэжлийн турилагатай баг – хамт олон үйлчлүүлэгч бүрийн сэтгэлд нийцсэн шинэлэг үйлчилгээгээрээ буудлын ор ашиглалтыг 2015 оноос 11% нэмэгдүүлнэ.

БОРЛУУЛАЛТ, МАРКЕТИНГ, ЗОЧНЫ ҮЙЛЧИЛГЭЭ:

Зах зээл, үйлчилгээнд нийцсэн үнийн санал гаргаж хэрэгжүүлнэ
Хөнгөлөлт, урамшуулалт, идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төвлөвлөгөө гаргана
Зочид буудлын захиалгын On-line сайтуудтай шууд холбоо тогтоож хамтран ажиллана
Шинэ үйлчилгээ гаргах, Багц бүтээгдэхүүний олон төрлийн үнэ гаргах
Зочны үйлчилгээнд тохилог аюулгүй орчинг бүрдүүлж, найрсаг харилцаа зочин бүрт мэдрүүлнэ.
Компанийн давуу талаа ашиглах боломж, судалгаа хийх, хэрэгжүүлэх
Хуучин харилцагчдаа татах, тэдэнд шинэ багц, нэмэлт үйлчилгээ санал болгох

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТОХИЖИЛТЫН:

Зочны үйлчилгээнд нийцсэн их засвар, тохижилтын ажил хийх, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх
Шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, шинээр худалдан авах
Буудлын гарна тохижилт, фасад, гарц, реклами чимэглэлийн засвар тохижилт хийнэ
Буудлын зочны өрөөний тавилага шинэчлэх
Зочны үйлчилгээний шаазан эдлэл, шилэн эдлэлийг шинэчлэх
Wi-Fi интернэтийн шинэчлэл хийх
Телевизийн сувгийн сонголт, сигналын чанарыг сайжруулах

КОМПАНИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХАРИУЦЛАГА:

Харилцагч байгууллагын уулзалт арга хэмжээг зохион байгуулах, /Бүх чиглэлийн байгууллагуудтай уулзалт хийх/
Хувьцаа эзэмшигчтэй харилцаатай ажиллах, уулзалт хийх, эзлжит хурал зохион байгуулах
Нийгэмд чиглэн зохион байгуулагдсан ажлуудад оролцох, хамтран ажиллах
Спорт, урлагийн арга хэмжээ, тэмцээнийг дэмжих ажиллах

ӨРТӨГ, ЗАРДАЛ ХЯМДРУУЛАХ:

Алба нэгж бүр зардлын бодит судалгаа гарган, дүгнэлт хийх, зардал хэмнэх ажил зохион байгуулж
Тогтмол болон урсгал зардлын хэмнэлт гаргах
Зардлын хэмнэлтийг тооцон урамшуулах, ажилтан нэг бүрийг оролцуулах /үнэ болон тоо хэмжээгээр/

2015 оны хэтэрсэн зардал тус бүр дээр судалгаа хийх /үнэ болон тоо хэмжээгээр/

Хасч болох, багасгак болох зардлын судалгаа хийж хэрэгжүүлэх аян зохион байгуулна
Хоолны өртөг хямдруулж, урамшуулалт олгох тогтолцоог хэрэгжүүлнэ
Бүтэц, орон тоог зөв зохион байгуулж, цалин, урамшлыг боловсронгуй болгоно

АЖИЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ, ХӨГЖИЛ, СУРГАЛТ:

Ажиллагдын сургалт, хөгжил, нийгмийн асуудлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх
Компани дээр мөрдөгдөх буй дүрэм, журам, ажлын байрны тодорхойлопт, стандартыг шинэчлэх
Ажлын байрны сургалтыг байнга зохион байгуулах, сургалтын хөтөлбөр гаргах
Ажиллах хүчний залгамж халааг бэлтгэх, мэргэжлийн сургуультай хамтран ажиллах, урт хугацааны хөтөлбөр боловсруулах
Ажиллагдынхаа байр орон сууцны нөхцөлийг сайжруулах, урт хугацааны зээлд хамруулах тал дээр дэмжлэг үзүүлэх

ЭКО-НОГООН ХӨГЖИЛ, ЭРҮҮЛ ОРЧИН, ЭРҮҮЛ ХҮНС ЧИГЛЭЛЭЭР:

Буудлын орчинд ногоон байгууламж, мод тарих, зулэгжүүлэх, цэцэрлэгжүүлэх ажил хийх
Зочны үйлчилгээнд эрүүл, аюулгүй, тайван орчныг бүрдүүлж өгөх
Эрүүл, баталгаатай хүнсний бүтээгдэхүүнээр зонинд үйлчлэх
Цахилгаан бага хэрэглэдэг гэрэл чийдэн, төхөөрөмж ашиглах
Ногоон санамжийн хуудсын дагуу цагаан хэрэглэлийг солих
Усны хэрэглээ, цэвэрлэгээний бодисын хэрэглээг зохистой болгох
Байгальд ээлтэй хэвлэмэл материал болон уут, торыг ашиглах



“БАЯНГОЛ-ЗОЧИД БУУДАЛ”
ХК-ИЙН УДИРДЛАГАД

“ФИСКАЛ АУДИТ” ХХК
210643 Улаанбаатар хот, Монгол улс
Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн орчин чөлөө,
Бизнес шаазай1, 503 тоот
Утас/факс: (976)- 70106099, 99991914
E-mail: audit@fiscal.mn, info@fiscal.mn

2016-04-23 № СТ-16/14

таний _____-ны № _____-т

ХАРААТ БҮС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид “Баянгол-Зочид Буудал” ХК-ийн 2015 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дусгавар болсон орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайлан (цаашид “санхүүгийн тайлан” гэнэ)-д аудит хийжээ.

Санхүүгийн тайланыг талаархи компанийн удирдлагын хариуцлага

Санхүүгийн тайлан Сангхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв болтгэж тайлагнах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага юм. Энэхүү үүрэг хариуцлагад няягтан бодох бүртгэлийн зохицой болдогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдал тохирсон няягтан бодох бүртгэлийн арга тооцооллыг хийж, аливаа заль мэх, хэвийн бус үйлдлээс сэргийлэх болон ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх эзргэх нь багтана.

Аудиторын хүлээн хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол хийсэн аудитын ажилдаа үндэслэн санхүүгийн тайланд харахаас бус байдалаар дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгээн. Аудитын Олон Улсын Стандартын дагуу бид санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн талаархи хүчин төгөлдөр, хангалттай нотолгоог олж авахын тулд аудитын төлөвлөж гүйцэтгээг. Санхүүгийн тайлан дахь дун болон тодруулгын талаархи аудитын нотолгоог олж авахын тулд зохих горимуудыг гүйцэтгэх нь мөн аудитын ажилд хамаардаг.

Горимын сонголт нь аудиторын мэргэжлийн үнэлэлт дүгнэлтээс хамаарах бөгөөд үүнд зилилан буюу алдааны улмаас санхүүгийн тайланг материаллагар буруу илэрхийлэх эрэлдийн үнэлгээ хамаарна. Эдгээр эрэлдийн үнэлгээг хийхдээ аудитор нь санхүүгийн тайлан үнэн зөв болтгын толиулуулхатхийн холбогтой байгууллагын дотоод хяналтын системийг харгалзан узх бөгөөд энэ нь байгууллагын дотоод хяналтын үр дүнтэй байдалын талаар дүгнэлт гаргах биш, харин тухайн нөхцөл байдал тохирсон аудитын горимуудыг тодорхойлоход чиглэнэ. Аудитад мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэгж байгаа няягтан бодох бүртгэлийн болдогуудын зохицой эсэх, няягтан бодох бүртгэлийн тооцоолуудын бодиттой эсэхийг үнэлэх ажлуул баатгана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр “Баянгол-Зочид Буудал” ХК-ийн 2015 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр дусгавар болсон үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлийн хувьд Сангхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бөгөөд бодитой илэрхийлсэн байна.



ЗАХИРАЛ

Д.АЛТАНТӨГС



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ “ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХХIII ХУРЛЫН ТОГТООЛ”

2016.04.28

№1

Улаанбаатар хот

Хурал хүчин төгөлдөрт тооцох тухай

“Баянгол зочид буудал”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ХХIII хурлын тооллогын комиссын бүртгэлийн мэдээ, Компанийн дүрмийн 7.4 зүйлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянгол зочид буудал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 23-р хуралд 423055 ш хувьцааг эзэмшсэн, хувь нийлүүлэгчдээс, ирсэн ш хувьцааг эзэмшсэн,..... хувь нийлүүлэгч нь нийт хувьцааны хувь болсон тул Компанийн тухай хуулийн 69.1 дүгээр зүйл, Компанийн дүрмийн 7.4 дүгээр зүйлийг үндэслэн хурлыг хүчин төгөлдөрт тооцон хуралдуулсугай.

Хурлын дарга / /



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХХIII ХУРЛЫН ТОГТООЛ

2016.04.28

№2

Улаанбаатар хот

ТОГТООЛ БАТЛАХ ТУХАЙ

Хувьцаа эзэмшигчдийн ХХIII хурлаас ТОГТООХ нь :

1. ”Баянгол зочид буудал” Хувьцаат компанийн 2015 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг зөвшөөрч, 2016 оны зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг даалгасугай.
2. Компанийн ТУЗ-ийн 2016 оны зардлыг баталсугай..

Хурлын дарга / /



Bayangol Hotel

Since 1964